



БУЛГАН АЙМАГ ДАХЬ  
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Булган аймгийн Баяннуур сумын Засаг даргын 2025 оны санхүүгийн  
нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн  
аудитын хураангуй тайлан

Аудитын код: БУА-2026/4/НА-СТА-ТТЗ

Цахим хуудас:  
[www.open.audit.mn](http://www.open.audit.mn)

Булган аймаг  
2026 он

Булган аймаг дахь төрийн аудитын газрын дарга бөгөөд  
Тэргүүлэх аудитор: Д.Батцогт  
Утас:7034-2580 Цахим хаяг: [Bulgan@audit.gov.mn](mailto:Bulgan@audit.gov.mn)

Аудитын менежер: Ж.Энхцоодол  
Утас:9905-7478 Цахим хаяг: [Enkhtsoodolj@audit.gov.mn](mailto:Enkhtsoodolj@audit.gov.mn)

Аудитор: С.Цэдэнлхам  
Утас:9982-8263 Цахим хаяг: [Tsedenkham@audit.gov.mn](mailto:Tsedenkham@audit.gov.mn)

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.



**БУЛГАН АЙМАГ ДАХЬ  
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

Анхдагчдын өргөн чөлөө 1-120,  
Жаргалант, 5-р баг, Булган сум, Булган аймаг,  
63082, Утас/Факс: 7034-2580  
Цахим шуудан: bulgan@audit.gov.mn

2026.03.25 № 343  
танай \_\_\_\_\_ ны № \_\_\_\_\_ т

Баяннуур сумын засаг  
дарга Б.ЁНДОН ТАНАА

**Өөрчлөлтгүй дүгнэлт**

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.2-д заасны дагуу Баяннуур сумын Төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Баяннуур сумын Төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

**Дүгнэлтийн үндэслэл**

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

**Асуудлыг онцолсон хэсэг**

2025 оны төсвийн жилд улсын төсвийн орлогын бүрдүүлэлтээс шалтгаалсан төсвийн зарлагын хязгаарлалт хийгдсэн, "Төсвийн сахилга бат, хариуцлагыг чангатгах тухай" Монгол Улсын Ерөнхий сайдын 2025 оны 12 дугаар сарын 10-ны өдрийн 05 дугаар албан даалгаврын хэрэгжилтийн хангаж ажилласан байна.

**Аудитын гол асуудал**

Сумын Засаг даргын 2024-2028 онд хэрэгжүүлэх үйл ажиллагааны "Төрөлх нутгаа хөгжүүлэе" хөтөлбөрт тусгагдсан 4 бүлэг, 15 зорилт, 156 арга хэмжээний хэрэгжилтийг 2025 оны жилийн эцсийн байдлаар 85 хувь буюу үр дүнтэй гэж сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2025 оны VII/40 дүгээр тогтоолоор дүгнэсэн байна.

6326950530

Санхүүгийн тайланд өгсөн бидний дүгнэлт бусад мэдээллийг хамраагүй ба үүнд ямар нэг төрлийн баталгаажуулах дүгнэлт гаргаагүй болно.

**Удирдлага болон Засаглах эрх бүхий этгээдийн санхүүгийн тайланд хүлээх үүрэг, хариуцлага**

Удирдлага нь санхүүгийн тайланг Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Санхүүгийн тайлагналын олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

**Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага**

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гаргах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА,  
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Д.БАТЦОГТ

**Хоёр. Санхүүгийн ба төсвийн гүйцэтгэлийн тайлангийн гол үзүүлэлтүүд**

(мянган төгрөгөөр)

	<b>Үзүүлэлт</b>	<b>2024.12.31</b>	<b>2025.12.31</b>
<b>Санхүүгийн байдлын тайлан</b>			
	Эргэлтийн хөрөнгийн дүн	701,631.2	645,134.5
	Эргэлтийн бус хөрөнгийн дүн	2,476,605.9	3,184,242.0
	<b>Нийт хөрөнгийн дүн</b>	<b>3,178,237.1</b>	<b>3,829,376.5</b>
	Нийт өр төлбөрийн дүн	14,725.9	110,087.0
	Цэвэр хөрөнгө/өмчийн дүн	3,163,511.2	3,719,289.5
	<b>Өр төлбөр, цэвэр хөрөнгө/өмчийн дүн</b>	<b>3,178,237.1</b>	<b>3,829,376.5</b>
<b>Санхүүгийн үр дүнгийн тайлан</b>			
	Үйл ажиллагааны орлогын дүн	1,991,138.1	2,088,624.3
	Үйл ажиллагааны зардлын дүн	1,730,745.1	1,722,505.7
	<b>Үйл ажиллагааны үр дүн</b>	<b>260,393.0</b>	<b>366,118.6</b>
	Үйл ажиллагааны бус үр дүн	-	-
	<b>Үйл ажиллагааны нийт үр дүн</b>	<b>260,393.0</b>	<b>366,118.6</b>
<b>Цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан</b>			
	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	2,903,118.3	3,353,170.9
	Тайлант оны үр дүн	260,392.9	366,118.6
	<b>Эцсийн үлдэгдэл</b>	<b>3,163,511.2</b>	<b>3,719,289.5</b>
<b>Мөнгөн гүйлгээний тайлан</b>			
	Үйл ажиллагааны мөнгөн орлогын дүн	1,948,901.4	1,710,912.7
	Үйл ажиллагааны мөнгөн зарлагын дүн	1,369,530.2	1,380,903.5
	<b>Үйл ажиллагааны ЦМГ</b>	<b>579,371.2</b>	<b>330,009.2</b>
	<b>Хөрөнгө оруулалтын ЦМГ</b>	<b>(219,063.8)</b>	<b>(320,001.4)</b>
	<b>Санхүүгийн ажиллагааны ЦМГ</b>	<b>(110,068.8)</b>	<b>(76,566.3)</b>
	<b>Нийт цэвэр мөнгөн гүйлгээ</b>	<b>250,238.6</b>	<b>(66,558.5)</b>
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	197,595.3	447,833.9
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	447,833.9	381,275.4
<b>Төсвийн гүйцэтгэлийн тайлан</b>			
	<b>Нийт зарлага ба цэвэр зээлийн дүн</b>	<b>1,623,975.5</b>	<b>1,772,060.5</b>
	Урсгал зардал	1,305,807.7	1,411,218.1
	Хөрөнгийн зардал	208,099.0	284,276.1
	Эргэж төлөгдөх төлбөрийг хассан цэвэр зээл	110,068.8	76,566.3
	<b>Зардлыг санхүүжүүлэх эх үүсвэр</b>	<b>1,623,975.5</b>	<b>1,772,060.5</b>
	Орон нутгийн төсвөөс санхүүжих	1,191,627.0	1,265,325.1
	Орон нутгийн хөгжлийн нэгдсэн сангаас шилжүүлсэн орлого	274,301.0	220,359.8
	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	158,047.5	72,586.6
	Урьд оны үлдэгдлээс санхүүжих		213,789.0

Баяннуур сумын Засаг даргын 2024-2028 онд хэрэгжүүлэх “Төрөлх нутгаа хөгжүүлэе” үйл ажиллагааны мөрийн хөтөлбөр нь нийгмийн дунд өөрийгөө бие даан авч явах чадвартай залуу үеийг төлөвшүүлж өсгөх, ажил амьдралын зөв хандлагатай, сум орон, улс нийгэмдээ хувь нэмрээ зохих ёсоор оруулж яваа нийгмийн идэвхтэй давхаргыг бий болгох, ажил амьдралын баялаг туршлагаа үр хүүхэд залуу үедээ өвлүүлсэн ахмад настнуудын эрүүл урт наслах орчинг бүрдүүлэх, ээлтэй орчинд боловсролыг хүн бүр эзэмших нөхцлийг бүрдүүлэх зэрэг зарчмыг баримтлан чанартай амьдралын баталгаа бүхий эрүүл иргэнийг хөгжүүлнэ” гэж тодорхойлсон байна.

Сумын Засаг дарга хуульд заасан дараах чиг үүргийг хэрэгжүүлж ажилласан байна. Үүнд:

- Сумын хөгжлийн үндсэн чиглэл, бодлого, төлөвлөлт;
- Сумын өмчийн ашиглалт, эзэмшилт, захиран зарцуулалт, түүнд тавих хяналт
- Сумын төсөв, түүний төлөвлөлт, гүйцэтгэл, тайлан, хяналт;
- Хууль тогтоомжид заасан хүрээнд албан татвар, төлбөр хураамжийн хувь хэмжээг тогтоох асуудал;
- Сумын орон нутгийн хөгжлийн сангийн төлөвлөлт, хуваарилалт болон бусад сангийн бүрдүүлэлт, зарцуулалт, тайлан, хяналт;
- Аймгийн хүний нөөцийн хөтөлбөрийн хэрэгжилт, ажиллах нөхцөл;
- Аймгийн хүнс, хөдөө аж ахуй, үйлдвэрлэлийн хөтөлбөрийн хэрэгжилт;
- Сумын хүн амын ундны болон ахуйн хэрэгцээний уст цэгийн төлөвлөлт, байршил, ашиглалт, хамгаалалт;
- Худалдаа, үйлчилгээний зохион байгуулалт, хяналт;
- Орон сууц, нийтийн аж ахуйн удирдлага;
- Суурин газрын замын хөдөлгөөн, авто зогсоолын зохицуулалт;
- Хөшөө дурсгалын байршил, хамгаалалт;
- Нийтийн эзэмшлийн зам, талбай, олон нийтийн соёл амралтын хүрээлэн, ногоон байгууламжийн ашиглалт, хамгаалалт;
- Аялал жуулчлалын үйл ажиллагааны зохицуулалт;
- Хог хаягдлын цэгийн байршил, энгийн хог хаягдлын менежмент;
- Оршуулгын газрын үйл ажиллагааны зохицуулалт;
- Сумын сургууль, цэцэрлэг, эмнэлэг, соёлын төв, номын сан, биеийн тамир, спортын барилга байгууламж, хөдлөх хөрөнгийн ашиглалт, засвар;
- Гал түймэр, үерийн хамгаалалтын байгууламж, суваг шуудуу, арчлалт;
- Орон нутгийн цэвэрлэх байгууламжийн арчлалт;
- Орон нутгийн зам, гүүр, тэмдэг, тэмдэглэгээ, арчлалт, хамгаалалт;
- Суурин газрын гэрэлтүүлэг, арчлалт;
- Бэлчээрийн ашиглалт, хамгаалалт;

### 3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа болон санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг дараах хууль тогтоомж, эрх зүйн актуудад өөрчлөлт орсон байна. Үүнд:

- Төсвийн тухай хууль;
- Монгол Улсын 2025 оны төсвийн тухай хууль;
- Аж ахуй нэгжийн орлогын албан татварын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хууль;
- Малчны тухай хууль;

- Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хууль;
- Үндэсний баялгийн сангийн тухай хуулийг дагаж мөрдөх журмын тухай хуульд нэмэлт оруулах тухай хууль;
- Хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг шинэчлэн тогтоох тухай хууль;
- Ахмад настны тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хууль;
- Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих тухай хуульд нэмэлт өөрчлөлт оруулах тухай хууль;
- Мэдээллийн технологийн үйлдвэрлэлийг дэмжих тухай хууль;
- Хот, тосгоны эрх зүйн байдлын тухай хууль;
- Сангийн сайдын 2025 оны 01 дүгээр сарын 03-ны өдрийн А/03 дугаар тушаалаар “Төсвийн байгууллагын дагаж мөрдөх, нягтлан бодох бүртгэлийн журам”;
- МУ-ын Ерөнхий сайдын 2025 оны 05 дугаар албан даалгавар;

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж буй дотоод хяналтаас төлөвлөлтийн үе шат, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөгүй байна гэж үзлээ.

Дотоод аудитын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын найдвартай байдлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах, дотоод аудитораас шууд туслалцаа авах шаардлагагүй гэж үзлээ.

Сумын Засаг даргын үйл ажиллагааны “Төрөлх нутгаа хөгжүүлэе” мөрийн хөтөлбөр 4 бүлэг, 15 зорилт, 156 арга хэмжээний хэрэгжилтийг сумын ИТХ-ын 2025 оны 12 дугаар сарын 18-ны өдрийн VII/40 дүгээр тогтоолоор 85.0 хувьтай “Үр дүнтэй” хэрэгжсэн гэж үнэлсэн байна.

#### **Дөрөв. Асуудлын онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг**

2025 оны төсвийн жилд улсын төсвийн орлогын бүрдүүлэлтээс шалтгаалсан төсвийн зарлагын хязгаарлалт хийгдсэн, “Төсвийн сахилга бат, хариуцлагыг чангатгах тухай” Монгол Улсын Ерөнхий сайдын 2025 оны 12 дугаар сарын 10-ны өдрийн 05 дугаар албан даалгаврын хэрэгжилтийн хангаж ажилласан байна.

Сумын Засаг дарга, Засаг даргын Тамгын газар нь 2025 онд Улсын Их Хурал, Засгийн газрын тогтоол, шийдвэр болон аймаг, сумын Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөрүүд, сумын эдийн засаг нийгмийг хөгжүүлэх зорилтуудыг хэрэгжүүлэхэд үйл ажиллагааг чиглэл болгон ажиллаж байна.

#### **Тав. Аудитын гол асуудал**

Сумын Засаг даргын 2024-2028 онд хэрэгжүүлэх үйл ажиллагааны "Төрөлх нутгаа хөгжүүлэе" хөтөлбөрт тусгагдсан 4 бүлэг, 15 зорилт, 156 арга хэмжээний хэрэгжилтийг 2025 оны жилийн эцсийн байдлаар 85 хувь буюу үр дүнтэй гэж сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2025 оны VII/40 дүгээр тогтоолоор дүгнэсэн байна.

#### **Зургаа. Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал**

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайланд өгөх аудиторын дүгнэлтээс тусад нь салгах хэрэгтэй гэж заасан байна.

## **Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт**

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор [www.shilendans.gov.mn](http://www.shilendans.gov.mn) цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Төсвийн төвлөрүүлэн захирагчийн шилэн дансны нэгдсэн цахим хуудсанд мэдээлбэл зохих 145 мэдээллээс мэдээллийг бүрэн мэдээлсэн боловч худалдан авах ажиллагааны төлөвлөгөөг хугацаа хоцроож мэдээлсэн, Бонд, зээл, өрийн бичиг, баталгаа, түүнтэй адилтгах санхүүгийн бусад хэрэгсэл, төр хувийн хэвшлийн түншлэлийн гэрээ, концесс, төсөв, өмч, хөрөнгө, мөнгө зарцуулах, өр, авлага үүсгэсэн аливаа шийдвэр 47 эрх зүйн актыг тухай бүр мэдээлэхээс 38 мэдээллийг хугацаа хоцроож дараа сарын 5-ны дотор мэдээлж, холбогдох файлыг хавсаргасан байна.

## **Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт**

### **Завсрын аудитын талаар**

Завсрын аудитад шалгагдагч байгууллагын 2025 оны 2 дугаар улирлын санхүүгийн тайланг хамруулж, урсгал зардал, нэмэлт санхүүжилтийн данснуудын хувьд горим, сорил хэрэгжүүлж, аудитын төлөвлөгөөг боловсруулан батлуулж ажиллалаа.

### **Өмнөх аудитын мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн**

Өмнөх аудитаар Баяннуур сумын Засаг дарга нь алдаа, зөрчилгүй ажиллаж, өгсөн төлбөрийн акт, албан шаардлага, зөвлөмж аваагүй байна.

## **Долоо. Дараагийн аудитаар анхаарах асуудал**

1.Тайланд оны малын тоо толгойн албан татварын орлого 48.4 сая төгрөгийг Төсвийн тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.2.8 дахь заалтад заасны дагуу сумын орон нутгийн хөгжлийн сан руу шилжүүлж орлогыг хаагаагүй, орон нутгийн ерөнхий орлогын дансны үлдэгдлээр тайлагнасан байна. Санхүүжилтийн эрхийг нээж, санхүүжилт олгохдоо батлагдсан төсөв, хуваарийн дагуу нээж байгаа эсэхийг хянан үзэх,

2.Төсвийн төвлөрүүлэн захирагч нь тайлант онд хэрэгжүүлэх хөтөлбөр, хөтөлбөрийн хүрэх үр дүнгийн талаарх чанарын болон тоо хэмжээний үзүүлэлтийн хэрэгжилт, үр дүнг тайлагнаагүй байна. Төсвийн төвлөрүүлэн захирагч тайлант оны төсвийг зарцуулаад хэрэгжүүлсэн төсөл, хөтөлбөр, хүрсэн үр дүнг тайлагнуулж, дараагийн аудитаар анхаарч үзэх нь зүйтэй гэж үзлээ.

## **Найм. НЭГТГЭСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАНД ХИЙСЭН АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ**

Аудитаар 3.1 сая төгрөгийн зөрчил илэрсэнд 3.1 сая төгрөгийн зөрчилд 1 албан шаардлага өгч, 2 зөвлөмж өглөө.

Нийт илрүүлсэн алдаа, зөрчлөөс залруулагдаагүй 3.1 сая төгрөгийн зөрчил нь бидний тогтоосон материаллаг байдлын түвшнээс 28.7 сая төгрөгөөр дутуу байгаа тул “Өөрчлөлтгүй” дүгнэлт өглөө.

### **8.1 Зөвлөмж**

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

### **Төсвийн төлөвлөлттэй холбоотой асуудал**

**1.1 Илрүүлэлт:** Төсвийн орлогын төлөвлөгөө 87.5 хувьтай биелэж, 10 нэр төрлийн орлогын төлөвлөгөөний биелэлт хангалтгүй байна.

**Өгсөн зөвлөмж:** Орон нутгийн төсвийн орлогын төлөвлөгөөг биелүүлэхэд нөөц боломжоо дайчлан, чиг үүргийн хяналтыг тухай бүр хэрэгжүүлэх, ажил зохион байгуулж ажиллах.

**1.2 Илрүүлэлт:** Тайлант онд жижиг дунд үйлдвэрлэлийг дэмжих санг 100.0 сая төгрөгөөр баталж, төсвийн тодотголоор 50.0 сая төгрөг болгон батлуулсан. Гүйцэтгэлээр 11.2 сая төгрөгийн орлого орсон байна.

**Өгсөн зөвлөмж:** Тусгай сангийн орлого, зарлагыг тухайн жилийн төлөвлөгөө, зорилтот түвшинтэй уялдуулан үндэслэлтэй төлөвлөх

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

## 8.1 Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл:

### Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл

(сая төгрөгөөр)

Байгууллагын нэр	Нийт алдаа		Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан		Буруу тусган илэрхийлсэн		Үүнээс				Зөвлөмж	
							Залруулсан		Залруулаагүй			
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
	-	-	-	-	-	-	-	-	-	-	-	-

### Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

(сая төгрөгөөр)

Байгууллагын нэр	Нийт зөрчил		Үүнээс									
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хариуцлага тооцуулах албан шаардлага		Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Албан тушаалт-ны тоо	Тоо	Дүн
Ерөнхий боловсролын сургууль, хүүхдийн цэцэрлэгт батлагдсан төсвөөс илүү санхүүжилт олгосноос шалтгаалан төсөв хэтрүүлэн зарцуулсан.	1	3.1			1	3.1						
Орон нутгийн төсвийн орлогын төлөвлөгөөг биелүүлэхэд нөөц боломжоо дайчлан, чиг үүргийн хяналтыг тухай бүр хэрэгжүүлэх, ажил зохион байгуулж ажиллах.	1	0.0					1	0.0				
Тусгай сангийн орлого, зарлагыг тухайн жилийн	1	0.0					1	0.0				

төлөвлөгөө, зорилтот түвшинтэй уялдуулан үндэслэлтэй төлөвлөх												
Дүн	2	3.1			1	3.1	2	0.0				

**Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал**

(сая төгрөгөөр)

Байгууллагын нэр	Нийт зөрчил		Үүнээс					
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой зөрчил								
Дүн	-	-	-	-	-	-	-	-